# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 21 он 06 сарын 30 өдөр

Дугаар 3Г-1/89

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000021402339

# МОНГОЛ УЛС
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 21 он 05 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 1008/1228

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 86 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга Ц.НЯМДОРЖ

000021507252

# МОНГОЛ УЛСЫН
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
# ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны 66 дугаар тэмдэглэлд:

“III.ХЭЛЭЛЦСЭН нь: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, http://www.mof.gov.mn

2021.05.03 № 5-2/2303

танай 2021.04.14 -ны № ХЭГ/1026 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн м[illegible]лэх зөвшөө[illegible]г үүгээр олгож байна.

Б.ЖА[illegible]ЛАН

9764002781

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл foreign@mojha.gov.mn,
Вэбсайт: www.mojha.gov.mn

2020.12.14 № 1/2061

танай -ны № ХЭГ/2824-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Х.НЯМБААТАР

1 28 5 ШТТ6740

Doc.yam a5.2020

| БАТЛАВ | БАТЛАВ | БАТЛАВ |
| --- | --- | --- |
| МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА | САНГИЙН САЙД | ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД |
| Л.ОЮУН-ЭРДЭНЭ | Ч.ХҮРЭЛБААТАР | Х.НЯМБААТАР |

# ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

## Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт "Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд өөрчлөлт оруулж байгаа хууль тус бүрд үзэл баримтлалыг тодорхойлох шаардлагагүй." гэж заасны дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, бусад хуулийг уг хуульд нийцүүлэх зорилгоор холбогдох хуулийн төслүүдийг боловсруулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна.

### 1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д "... Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна." гэж хуульчилсан. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдмэл, цогц, уялдаатай байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Түүнчлэн "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолын 1 дэх заалтын 4-т зааснаар Төсвийн тухай болон холбогдох бусад хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулахыг Засгийн газарт даалгасан.

### 1.2. Практик шаардлага

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн

бодлого, төлөвлөлт, тэдгээрийн уялдаа, хоорондын нийцлийг хангаж, түүнийг боловсруулан батлах тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Гэвч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хуулиуд нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцэхгүй байгаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлт болон түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд тодорхойгүй нөхцөл байдал бий болгож байна.

Иймд холбогдох хуулиудын уялдааг хангаж нийцүүлэх практик шаардлага үүсээд байна.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Холбогдох хуулийн төсөлд дээр дурдсан практик хэрэгцээ шаардлагад үндэслэн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалтын уялдаа, нийцлийг хангаж, зарим нэр томьёоны тайлбарыг нэмэх, Засгийн газрын бүрэн эрх, Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг болон дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, богино хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт зарим өөрчлөлтийг хийх, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох зохицуулалтыг тусгана.

2.Бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх субъектийн эрх, үүрэг, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн нэршлийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлнэ. Тухайлбал, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад тусгагдсан нэг жилийн хугацаанд хэрэгжих “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэснийг “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж, “стратеги, хөтөлбөр” гэснийг “бодлого, хөтөлбөр” гэж, “хөтөлбөр” гэснийг “төлөвлөгөө” гэх зэргээр өөрчилнө.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал үүсэхгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгарах асуудал арилж, хууль хэрэгжүүлэхэд тусламдаж буй сөрөг үр дагавар арилна.

**Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай уялдаж, нийцсэн байдал. Тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй дагалдан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол,

сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

-----oOo-----

## ТАНИЛЦУУЛГА

## ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д "Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна." гэж заасантай холбогдуулан Улсын Их Хурлын хаврын чуулганаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталсан билээ.

"Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 4 дүгээрт Төсвийн тухай болон холбогдох бусад хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулахыг Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга, Сангийн сайд нарын 2020 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 56/169 дүгээр хамтарсан тушаалаар тус хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулан ажиллав.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт, тэдгээрийн уялдаа, хоорондын нийцлийг хангаж, түүнийг боловсруулан батлах тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Гэвч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хуулиуд нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцэхгүй, хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд тодорхойгүй нөхцөл байдал бий болгож байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт "Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно." гэж заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Төсвийн тухай болон бусад хуулийг нийцүүлэх зорилгоор холбогдох хуулийн төслүүдийг боловсруулллаа.

Хуулийн төсөлд дээр дурдсан практик хэрэгцээ шаардлагад үндэслэн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгав. Үүнд:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалтын уялдаа, нийцлийг хангаж, зарим нэр томьёоны тайлбарыг нэмэх, Засгийн газрын бүрэн эрх, Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг болон дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, богино хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт зарим өөрчлөлтийг хийх, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох зохицуулалтыг тусгана.

2. Бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх субъектийн эрх, үүрэг, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн нэршлийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлнэ. Тухайлбал, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад тусгагдсан нэг жилийн хугацаанд хэрэгжих "улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл" гэснийг "улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж, "стратеги, хөтөлбөр" гэснийг "бодлого, хөтөлбөр" гэж, "хөтөлбөр" гэснийг "төлөвлөгөө" гэж өөрчлөхөөр тусгалаа.

Хуулиудын төсөл батлагдсанаар төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй, нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар гарахгүй. Монгол Улсын Төсвийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал арилна.

Энэ хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

Яамдаас ирүүлсэн саналыг тусгахдаа хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх, нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх, тогтвортой, тасралтгүй залгамж чанартай байх зарчмыг баримталсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байгаа **52** хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулиудын төслийг бэлтгэсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт:**

“4.1.9.“Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг;”

**2/4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт:**

“4.1.12.“Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” гэж орон нутгийн онцлогт нийцсэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг;”

**3/6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэг:**

“6.11.Бусад хууль тогтоомжид заасан төрөөс баримтлах бодлого гэснийг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөлд хамааруулж, үндэсний хөтөлбөр гэснийг мөн зүйлийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тус тус хамааруулж ойлгоно.”

**4/6 дугаар зүйлийн 6.12 дахь хэсэг:**

“6.12.Засгийн газар энэ хуулийн 6.8.2, 16.3-т заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлахдаа тухайн цаг үед тулгамдаж байгаа зайлшгүй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай эрсдлийн үеийн төсөл, арга хэмжээг Улсын Их Хуралд танилцуулснаар төлөвлөгөөндөө тусгаж болно.”

**5/6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсэг:**

“6.13.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой төрийн бодлогын баримт бичиг болон гамшиг, онц, дайны байдлын үеийн төлөвлөгөө нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл биш бөгөөд энэ хуулиар зохицуулахгүй.”

**2 дугаар зүйл.**Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/6 дугаар зүйлийн 6.7.1 дэх заалт:**

“6.7.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь дараах шаардлагыг хангасан байна:

6.7.1.а.урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилийн хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх хүрэх түвшинг тодорхойлсон байх;

6.7.1.б.хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн салбар болон салбар хоорондын уялдааг хангасан байх;

6.7.1.в.тухайн таван жилд тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хавсаргах."

**2/6 дугаар зүйлийн 6.7.2 дахь заалт:**

"6.7.2.Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь дараах шаардлагыг хангасан байна:

6.7.2.а.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцсэн, түүнд тусгасан хүрэх үр дүнг аймаг, нийслэл, хотын онцлогт нийцүүлэн тодорхойлсон байх;

6.7.2.б.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнд уялдуулан орон нутгийн онцлогийг харгалзан зорилго, зорилт, хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх хүрэх түвшинг орон нутгийн түвшинд тодорхойлсон байх;

6.7.2.в.Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцсон төсөл, арга хэмжээг тусгасан хөтөлбөрийг хавсаргах."

**3/6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэг:**

"6.8.Дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна:

6.8.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:

6.8.1.а.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнд хүрэхээр чиглэсэн байх;

6.8.1.б.Хөгжлийн зорилтот хөтөлбөрт заасан төсөл, арга хэмжээтэй уялдсан байх;

6.8.1.в.хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн салбар болон салбар хоорондын уялдааг хангасан байх;

6.8.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна:

6.8.2.а.зорилго, зорилт, түүнийг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээг салбар, бүс нутаг, байршил, санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх;

6.8.2.б.үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тооцож боловсруулсан байх.

6.8.3.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:

6.8.3.а.Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг сонгон боловсруулсан байх;

6.8.3.б.Хөгжлийн зорилтот хөтөлбөрт заасан төсөл, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

6.8.3.в.тухайн орон нутгийн хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн улсын, бүсийн болон орон нутгийн хөгжлийн зорилтуудтай уялдсан байх;

6.8.3.г.бүс нутгийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлж, харилцан уялдаатай хөгжих боломжийг хангасан байх.

6.8.4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна:

6.8.4.а.зорилго, зорилт, түүнийг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх;

6.8.4.б.үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тооцож боловсруулсан байх."

**4/9 дүгээр зүйлийн 9.3.7, 9.3.8 дахь заалт:**

"9.3.7.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам батлах"

9.3.8.хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх журам болон тайлангийн үлгэрчилсэн загварыг тус тус батлах;"

**5/9 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалт:**

"9.4.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар санал дүгнэлт боловсруулж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;"

**3 дугаар зүйл.**Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын "санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан төлөвлөсөн үйл ажиллагаа" гэснийг "нөөцөд суурилан боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр" гэж, мөн зүйлийн 4.1.15 дахь заалтын "хангасан үйл ажиллагааны бүрдлийг" гэснийг "тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай зэрэг өөрчлөлтийг" гэж, мөн зүйлийн 4.1.18, 4.1.21 дэх заалтын "үзүүлэлтийг" гэснийг "утгыг" гэж, мөн зүйлийн "4.1.9, 4.1.10" дахь заалтын дугаарыг "4.1.10, 4.1.11" гэж, мөн зүйлийн "4.1.11-4.1.25" дахь заалтын дугаарыг "4.1.13-4.1.27" гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгжээс" гэснийг "орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан

ажилтнаас" гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.2, 9.3.1, 9.4.2, 9.6.1 дэх заалтын "4.1.11" гэснийг "4.1.13" гэж, мөн зүйлийн 9.4.7 дахь хэсгийн "төрийн бүх шатны" гэснийг "оролцох төрийн байгууллага" гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн "45 хоногт" гэснийг "90 хоногт" гэж, 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсгийн "12 дугаар сарын 10-ны" гэснийг "10 дугаар сарын 01-ний" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

## ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийн “гэрээ,” гэсний дараа “төр хувийн хэвшлийн түншлэл” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“28.11.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**3 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэснийг “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж, мөн зүйлийн 10.3 дахь хэсгийн “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн” гэснийг “улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний” гэж, 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийн “энэ хуулийн 28.6-д заасны дагуу” гэснийг “хууль тогтоомжид нийцүүлэн” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалтын “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “урт хугацаанд” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “Түүнчлэн энэ хуулийн 28.1-д зааснаас бусад, нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төслийн саналыг төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдамжид заасны дагуу тус тус бэлтгэж үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 8.4.3-т заасан хугацаанд ирүүлнэ.” гэсэн 2 дахь өгүүлбэрийг, 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсгийн “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл,” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалт, 12.2.2 дахь заалт, $12^1$ дүгээр зүйл, 28 дугаар зүйлийн 28.3.6 дахь заалт, 28.3.7 дахь заалт, 28.8 дахь хэсэг, 28.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Авто замын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “батлах” гэснийг “хэрэгжүүлэх” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Авто замын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “баталж” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын "үндэсний хөтөлбөрийг батлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах" гэснийг "бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх " гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийн “үзэл баримтлалд” гэснийг "бодлогод” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Ахмад настны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн "хөтөлбөрийг" гэснийг "төлөвлөгөөг" гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын "хөтөлбөрийг Засгийн газар," гэснийг "төлөвлөгөөг Хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн "хөтөлбөр" гэснийг "төлөвлөгөө" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

| | |
|---|---|
| 2021 оны ... дугаар<br>сарын ... -ны өдөр | Улаанбаатар<br>хот |

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аялал жуулчлалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугээр зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.1 дэх заалтын “хөтөлбөр” гэснийг “төлөвлөгөө” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “батлах,” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.7 дахь заалтын “батлах” гэснийг “хэрэгжүүлэх” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## БАЯЖУУЛСАН ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Баяжуулсан хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын "үндэсний хөтөлбөрийг" гэснийг "бодлого хөтөлбөрийг" гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын "үндэсний хөтөлбөр батлах" гэснийг "бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх", 6.2.3 дахь заалтын "үндэсний хөтөлбөрийг" гэснийг "бодлого хөтөлбөрийг" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.12.1 дэх заалтын “хөтөлбөр,” гэснийг тус тус хассугай

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр | Улаанбаатар хот

## БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын "батлах" гэснийг "боловсруулах" гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтын "үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг" гэснийг "төлөвлөгөөг" гэж, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын "үзэл баримтлал" гэснийг "бодлого" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

# ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын “эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тогтвортой хөгжлийн бодлого, хөтөлбөрт" гэснийг "хөгжлийн бодлого төлөвлөлт, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “төрөөс баримтлах бодлого, төсөл, хөтөлбөр,” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

# ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын "бодлого, үндэсний хөтөлбөрийг баталж" гэснийг "бодлого, хөтөлбөрийг" гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтын "эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл" гэснийг "хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж, "хөтөлбөрийн" гэснийг "төлөвлөгөөний" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “үндэсний хөтөлбөр батлах” гэснийг “төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын "улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл" гэснийг "улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зэвсэгт хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын "батлах" гэснийг "хэрэгжүүлэх" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтын "хөтөлбөр" гэснийг "төлөвлөгөө" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “стратеги хөтөлбөр батлах” гэснийг “бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх”, 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын "урт болон богино хугацааны хөтөлбөр” гэснийг "дунд болон богино хугацааны төлөвлөгөө” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд" гэснийг "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Инновацийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын "бодлогыг батлах" гэснийг "бодлого" гэж, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын "хөтөлбөр" гэснийг "төлөвлөгөө" гэж, 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын "хөтөлбөр батлах" гэснийг "ажлыг зохион байгуулах" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"7.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон эсхүл хуульд заасан хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн төслийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлнэ."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийн "үзэл баримтлалд" гэснийг "бодлогод" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн "үндэсний хөтөлбөрийг" гэснийг "төлөвлөгөөг" гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн "үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг" гэснийг "төлөвлөгөөг" гэж, мөн хэсгийн "зохион байгуулна" гэснийг " хэрэгжүүлнэ" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“16.1.Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 7.2-т заасан тайланг үндэслэн малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, ашиглах, хөгжүүлэх асуудлыг хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 хэсгийн "энэ хуулийн 16.1-д заасан үндэсний" гэснийг “хөгжлийн бодлого” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “энэ хуулийн 16.1-д заасан үндэсний” гэснийг “улсын хөгжлийн бодлого,” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

| | |
|---|---|
| 2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр | Улаанбаатар хот |

## МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын хилийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.4 дэх заалтын “хөтөлбөрийг” гэснийг “төлөвлөгөө” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “тогтвортой хөгжлийн үзэл баримтлал,” гэснийг “урт болон” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

## МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтын "хөтөлбөрийг хэлэлцэж дүгнэлт" гэснийг "төлөвлөгөөг хэлэлцэж, дүгнэлт, зөвлөмж" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалтын "батлах" гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтын “үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг” гэснийг “үндэсний бодлого хөтөлбөр боловсруулж,” гэж, $22^1$ дүгээр зүйлийн $22^1$.1 дэх хэсгийн “үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар” гэснийг “үндэсний бодлого хөтөлбөрийг эрх бүхий байгууллагаар” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## НЯЛХ, БАЛЧИР ХҮҮХДИЙН ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалтын "үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах" гэснийг "бодлого, хөтөлбөрийн" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалтын "аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд" гэснийг "аймаг, нийслэл хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Орон сууцны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “хөтөлбөр батлах,” гэснийг “, бодлогын” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ОЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалтын “төлөвлөгөөг батлах” гэснийг “төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Ойн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

## ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг” гэснийг “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг” гэж, 18 дугаар зүйлийн 18.5.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт” гэснийг “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалтын “, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.2.7 дахь заалтын “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаж,” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1.19 дэх заалтын “дунд хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах” гэснийг, 9.3 дахь хэсгийн “, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусган” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.4.1 дэх заалтын “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулан” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсгийн “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар” гэснийг, 33.7 дахь хэсгийн “энэ хуулийн 33.6-д заасны дагуу” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.**Өрийн удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дугаар зүйл.** Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд" гэснийг "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

# СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

# ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсгийн “хөтөлбөрийг” гэснийг “үйл ажиллагааны төлөвлөгөөг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Усан замын тээврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “батлах” гэснийг “хэрэгжүүлэх” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.1.1.зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх”

**2 дугаар зүйл.**Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын “үндэсний хөтөлбөр, нэгдсэн” гэснийг “үйл ажиллагааны” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Харилцаа холбооны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын "бодлогыг батлах," гэснийг "бодлого," гэж, 6 дугаар зүйлийн 6.1.16 дахь заалтын "энэ хуулийн 5.1.4-т заасан хөтөлбөрийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх" гэснийг "Харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх" гэж, $6^1$ дүгээр зүйлийн $6^1$.6 дахь хэсгийн "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 20.2-т" гэснийг "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Харилцаа холбооны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын "үндэсний хөтөлбөрийг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалтын "стратеги" гэснийг, $6^1$ дүгээр зүйлийн $6^1$.6 дахь хэсгийн "дөрвөн жилд нэг удаа" гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хог хаягдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хөтөлбөрийг” гэснийг “журмыг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар батална” гэснийг “бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтын “баталж,” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | |
|---|---|
| 2021 оны ... дугаар<br>сарын ... -ны өдөр | Улаанбаатар<br>хот |

## ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “хөтөлбөр” гэснийг “төлөвлөгөө” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “үндэсний хөтөлбөр,” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хэмжил зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын "хөтөлбөр," гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## ХӨРС ХАМГААЛАХ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын "үндэсний хөтөлбөрийг батлах, түүнийг" гэснийг "үндэсний хөтөлбөрийг" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын "үндэсний хөтөлбөр батлах" гэснийг "үндэсний бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтын "төрөөс баримтлах" гэснийг "хөгжлийн" гэж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн "хөтөлбөрийг" гэснийг "үйл ажиллагааны төлөвлөгөөг" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.10 дахь заалтын "бодлого," гэснийг, 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсгийн "баталж" гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын "үндэсний хөтөлбөр баталж" гэснийг "батлагдсан бодлого, хөтөлбөрийг" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9.д. дэх заалтын "хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх жилийн," гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 дэх заалтын “хөтөлбөр,” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ЯАМДААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ**

(ЗГХЭГ-ын 2020 оны 10 сарын 14-ны өдрийн ХЭГ/2452, ХЭГ/ 2454 тоот албан бичгийн хариу)

| Д/д | Албан бичгийн дугаар, огноо | Саналын дугаар | Ирүүлсэн санал | Саналыг тусгасан эсэх тайлбар | Хуулийн заалт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын Шадар сайд 10/20/2020 ЗГ-2/789 | 1 | Хуулийн төслүүдтэй танилцаад дэмжиж байна | тусгах саналгүй | |
| 2 | Байгаль орчин аялал жуулчлалын яам 2020.10.22 1/1/7155 | 2 | **Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн** 5.1.2-ыг хуулиудийн төслийн саналаас хасах | саналыг тусгаж, төслөөс хуулийн заалтыг хассан | **5 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**<br>5.1.2.ус цаг уур, орчны мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчид мэдээлэх улсын сүлжээг зохион байгуулан түүний хөтөлбөрийг батлах; |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Батлан хамгаалах яам 2020.10.22 1а/3334 | 3 | **Монгол Улсын Засгийн газрын тухай хууль:** 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг "7.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ" гэснийг "7.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон эсхүл хуульд заасан хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ" гэж өөрчлөн найруулах; | "7.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон эсхүл хуульд заасан хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн төслийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ" гэж өөрчилж хуулийн төсөлд тусгав. | **26 дугаар зүйл.Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах**<br>~~7.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг Улсын Их Хурлаас тогтоосон хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн төслийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.~~<br>**7.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон эсхүл хуульд заасан хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн төслийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.** Хөтөлбөрт Засгийн газраас бүрэн эрхийнхээ хугацаанд эдийн засаг, нийгмийн хөгжил, төрийн удирдлагын хүрээний асуудлаар хийж гүйцэтгэх ажлын гол зорилт, хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээг тодорхойлно. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд хөгжлийн бодлого, зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, тухайн жилд хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн томоохон арга хэмжээ, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн уялдаа, хөрөнгийн эх үүсвэр, хариуцан хэрэгжүүлэх яам, байгууллагыг тусгана. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 4 | **Зэвсэгт хүчний тухай хууль:** 10.1.2" бодлогын хэрэгжилтийн" гэснийг" бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийн" гэж нэмэх, | УИХ-ын бүрэн эрхэд хамаарах тул хөндөхгүй. | **10 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх**<br>10.1.2.зэвсэгт хүчний хөгжлийн бодлогын хэрэгжилтийн талаар эрх бүхий албан тушаалтны мэдээлэл сонсох; |
| | | 5 | 12.1.1 "батлах" гэснийг "хэрэгжүүлэх" гэж өөрчлөх | хуулийн төсөлд тусгагдсан | **12 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх**<br>12.1.1.зэвсэгт хүчнийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг ~~батлах~~ **хэрэгжүүлэх**; |
| 4 | Боловсрол, шинжлэх ухааны яам 2020.10.21 1а /2337 | 6 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын 4.1.8 гэсний дараа 4.1.8[1] | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **9 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчийн эрх, үүрэг**<br>9.2.2.энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.10, 4.1.11-д заасан баримт бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан батлах; |
| | | 7 | 9.3.1 дэх заалтын 4.1.8 гэсний дараа 4.1.8[1] | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **9.3.Засгийн газрын бүрэн эрх:**<br>9.3.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.10, 4.1.11-д заасан баримт бичгийг хэрэгжүүлэх; |
| | | 8 | 9.4.2 дахь заалтын 4.1.8 гэсний дараа 4.1.8[1] | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **9.4.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг:**<br>9.4.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | удирдлага, зохион байгуулалтаар хангах; |
| | | 9 | 9.6.1 дэх заалтын 4.1.8 гэсний дараа 4.1.8[1] гэж тус тус нэмэх | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **9.6.Төрийн захиргааны төв байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:**<br>9.6.1.энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.10, 4.1.11-д заасан баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд оролцох; |
| | | 10 | **Инновацийн тухай хуулийн** 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх "үндэсний инновацийн тогтолцоо, инновацийг хөгжүүлэх хөтөлбөр батлах" гэсэн заалтыг хүчингүй болгох гэснийг "үндэсний инновацийн тогтолцоо, инновацийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх" гэж өөрчлөх | "хөтөлбөр батлах" гэснийг "ажлыг зохион байгуулах" гэж өөрчилж, төсөлд тусгав. | **6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**<br>6.1.4.үндэсний инновацийн тогтолцоо, инновацийг хөгжүүлэх ~~хөтөлбөр батлах~~ **ажлыг зохион байгуулах**; |
| 5 | Гадаад харилцааны яам 9/20/2020 8/1/4819 | 11 | Тусгайлан өгөх саналгүй | тусгах саналгүй | |
| 6 | Зам, тээврийн яам 2020.09.24 1/1/4510 | 12 | Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах эсэхэд анхаарч үзэх | саналыг үндэслэн төслөөс хасав. | |
| 7 | Сангийн яам 2020.10.22 5/2/6748 | 13 | **ХБТТУ-ын тухай хуулийн** 9.4.3. "хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл МУ-ын | "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд | **9 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчийн эрх, үүрэг**<br>9.4.3.~~макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион~~ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар санал, дүгнэлт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх | улсын төсвийн төсөл Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар санал, дүгнэлт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;” гэж өөрчилж, төсөлд тусгав. | ~~байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх~~;<br><br>9.4.3 **“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар санал, дүгнэлт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;** |
| | | 14 | **Хөгжлийн банкны тухай хуулийн** 10.1.1 заалтыг МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх гэж өөрчлөх | “тогтвортой хөгжлийн үзэл баримтлал,” гэснийг “урт болон” гэж өөрчилж, төсөлд тусгав. | **10 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх**<br><br>10.1.Хөгжлийн банк дараахь шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ:<br><br>10.1.1.Монгол Улсын ~~тогтвортой хөгжлийн үзэл баримтлал,~~ **урт болон** дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх; |
| | | 15 | **Хөгжлийн банкны тухай хуулийн** 4 дүгээр зүйлийг хүчингүй болгох | саналыг хуулийн төсөлд тусгасан. | ~~**4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**~~<br><br>~~4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:~~<br><br>~~4.1.1.“Монгол Улсын тогтвортой хөгжлийн~~ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | ~~үзэл баримтлал" гэж Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4.1.7-д заасныг;~~<br>~~4.1.2."дунд хугацааны хөгжлийн бодлого" гэж Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6.3, 6.4-т заасан баримт бичгийг.~~ |
| 8 | Соёлын яам 2020.10.19 1а /491 | 16 | Хуулийн төслүүдтэй танилцан зарчмын хувьд дэмжиж байна | тусгах саналгүй | |
| 9 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2020.10.20 1/1/2599 | 17 | Хуулиудын төсөлтэй танилцав. | тусгах саналгүй | |
| 10 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2020.10.26 1/1/3082 | 18 | **Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль: 1** дүгээр зүйл. 6.3.1 дэх заалтын "хөтөлбөрийг" гэснийг "төлөвлөгөөг" гэж өөрчлөх | "хөтөлбөрийг хэлэлцэж дүгнэлт" гэснийг "төлөвлөгөөг хэлэлцэж, дүгнэлт, зөвлөмж" гэж өөрчилж, төсөлд тусгасан. | **6 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл**<br>6.3.1.мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх урт, дунд болон богино хугацааны бодлого, ~~хөтөлбөрийг хэлэлцэж дүгнэлт~~ **төлөвлөгөөг хэлэлцэж, дүгнэлт, зөвлөмж** гаргах; |
| | | 19 | 2 дугаар зүйл 6.3.1 дэх заалтын "дүгнэлт" гэсний ард "зөвлөмж" гэж нэмэх | | |
| | | 20 | 3 дугаар зүйл. 8.4.1 дэх заалтын "хөтөлбөр" гэснийг хасах | "батлах" гэснийг хасаж өөрчилсөн. | **8 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний бүрэн эрх**<br>8.4.1.мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр ойрын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | болон хэтийн төлөвлөгөө, дүрэм, журам, заавар, үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг боловсруулах, ~~батлах,~~ хэрэгжүүлэх; |
| | | 21 | **Хүүхдийн эрхийн тухай хууль:** 11.1.2 дахь заалтын "хөтөлбөр, үйл ажиллагаа" гэснийг "төлөвлөгөө" гэж | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **11 дүгээр зүйл. Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх** 11.1.2.хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх, төсөв батлах; |
| | | 22 | 12.1.3 дахь заалтын "боловсруулан баталж" гэснийг хасах | "үндэсний хөтөлбөр," гэснийг хасав. | **12 дугаар зүйл. Засгийн газрын үүрэг, оролцоо** 12.1.3.хүүхдийг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах талаар ~~үндэсний хөтөлбөр,~~ төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах; |
| | | 23 | 15.1.1 дэх заалтын "хөтөлбөр" гэснийг "төлөвлөгөө" гэж тус тус өөрчлөх | хуулийн төсөлд тусгагдсан | **15 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын үүрэг, оролцоо** 15.1.1.тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, ~~хөтөлбөр~~ **төлөвлөгөө** боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах; |
| | | 24 | **Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль:** 11.1.4 дэх заалтын "хөтөлбөр" гэснийг "төлөвлөгөө" гэж тус тус өөрчлөх | хуулийн төсөлд тусгагдсан. | **11 дүгээр зүйл. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** 11.1.4.хөдөлмөрийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран малчин залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ~~хөтөлбөр~~ **төлөвлөгөө** боловсруулж хэрэгжүүлэх; |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 25 | 17.1.2 дахь заалтын "хөтөлбөр" гэснийг "төлөвлөгөө" гэж тус тус өөрчлөх | УИХ-ын бүрэн эрхэд хамаарах тул хөндөөгүй | **17 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**<br>17.1.2.залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлах; |
| | | 26 | 18.1.3 дэх заалтын " хөтөлбөр" гэснийг " төлөвлөгөө" гэж тус тус өөрчлөх | Хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **18 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**<br><br>18.1.3.залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, өргөн мэдүүлэх; |
| | | 27 | 18.1.2 дахь заалтыг хүчингүйд тооцох | саналыг тусгаж, төслөөс хуулийн заалтыг хассан | **18 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**<br>~~18.1.2. залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг батлах;~~ |
| | | 28 | **Ахмад настны тухай хууль:** 1 дүгээр зүйл. 9.2 дахь хэсгийн" хөтөлбөрийг" гэснийг "төлөвлөгөө" гэж | хуулийн төсөлд тусгагдсан | **9 дүгээр зүйл. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих**<br>9.2.Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ~~хөтөлбөрийг-~~ төлөвлөгөөг жил бүр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл баталж, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтан хэрэгжүүлнэ. |
| | | 29 | 11.1.1 дэх заалтын "хөтөлбөрийг Засгийн газар," гэснийг "төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага" гэж, | хуулийн төсөлд тусгагдсан | **11 дүгээр зүйл. Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих**<br>11.1.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настныг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх ~~хөтөлбөрийг Засгийн газар~~ **төлөвлөгөөг Хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | **эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага** баталж, хэрэгжүүлэх; |
| | | 30 | 14.1 дэхь хэсгийн "хөтөлбөр" гэснийг "төлөвлөгөө" гэж тус тус өөрчлөх | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **14 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг**<br>14.1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ахмад настны амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах, ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр боловсруулах, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ахмад настны талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах үүрэг хүлээнэ. |
| | | 31 | 14.2 дэхь хэсгийн "хөтөлбөр" гэснийг "төлөвлөгөө" гэж тус тус өөрчлөх | хуулийн төсөлд тусгагдсан | **14 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг**<br>14.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ахмад настны онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, насжилтын судалгааны төв, ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, тусгайлсан төсөл, ~~хөтөлбөр~~ **төлөвлөгөө** боловсруулж хэрэгжүүлэх, энэ талаархи |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах үүрэг хүлээнэ. |
| | | 32 | **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль**: 1 дүгээр зүйл. 8.2 дахь хэсгийн "хөтөлбөрийг" гэснийг "журмыг" гэж өөрчлөх | хуулийн төсөлд тусгагдсан. | **8 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ**<br>8.2.Нийтийн тээвэр, харилцаа холбоо, нийтийн үйлчилгээ, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, хиймэл эрхтэн, туслах болон асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, хэрэгсэл, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг дэмжих ~~хөтөлбөрийг~~ **журмыг** Засгийн газар батална. |
| | | 33 | 2 дугаар зүйл. 14.5 дахь хэсгийн "үндэсний хөтөлбөр" гэснийг "бодлого, хөтөлбөр" гэж өөрчлөх | "үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар батална" гэснийг "бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ" гэж өөрчилж, тусгав | **14 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх**<br>14.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх, бүх шатны боловсрол олгох ~~үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар батална~~. **бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ.** |
| | | 34 | 39.1.3 дахь заалтын "баталж" гэснийг хасах | хуулийн төсөлд тусгагдсан. | **39 дүгээр зүйл. Засгийн газрын чиг үүрэг**<br>39.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө ~~баталж,~~ хэрэгжүүлэх; |
| 11 | Хууль зүй, дотоод хэргийн яам 2020.11.03 1/1464 | 35 | **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль:** өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан "улсын хөгжлийн | "эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл" гэснийг "хөгжлийн жилийн төлөвлөгөө" | **19 дүгээр зүйл. Бүх шатны Засаг даргын чиг үүрэг**<br>19.1.4.орон нутгийн ~~эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл~~ **хөгжлийн жилийн төлөвлөгөө** болон төсөвт гэр бүлийн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | жилийн төлөвлөгөө" гэснийг "хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж | гэж өөрчилж, төсөлд тусгав | хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон ~~хөтөлбөрийн~~ **төлөвлөгөөний** төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; |
| | | 36 | 2 дугаар зүйлд заасан "бодлогыг" гэснийг "бодлого, хөтөлбөрийг" гэж өөрчлөх | "бодлого, үндэсний хөтөлбөрийг баталж" гэснийг "бодлого, хөтөлбөрийг" гэж өөрчилж, төсөлд тусгав. | **10 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаархи Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх**<br><br>10.1.2.төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар баримтлах ~~бодлого, үндэсний хөтөлбөрийг баталж,~~ **бодлого, хөтөлбөрийг** хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авах; |
| | | 37 | Төслийн 1, 2 дугаар зүйлийг нэгтгэх | нэгтгэсэн. | |
| | | 38 | **Цагдаагийн албаны тухай хууль**: 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсгийг хүчингүй болгохоор заасныг дэмжих боломжгүй | саналыг үндэслэн төслөөс хасав | **83 дугаар зүйл. Алба хаагчийн баталгаа**<br><br>83.3.Засгийн газар цагдаагийн алба хаагчийг орон сууцаар хангах хөтөлбөр баталж, хэрэгжүүлнэ. |
| | | 39 | 83.3 дахь хэсгийн "баталж," гэснийг хасаж, хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй нэгтгэх | "баталж" гэснийг хасаж, 2 дугаар зүйлтэй нэгтгэв. | **83 дугаар зүйл. Алба хаагчийн баталгаа**<br><br>83.3.Засгийн газар цагдаагийн алба хаагчийг орон сууцаар хангах хөтөлбөр ~~баталж,~~ хэрэгжүүлнэ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 40 | **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль**: 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтын "үндэсний стратеги" гэснийг "үндэсний бодлого, хөтөлбөр" гэж өөрчлөх | "үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг" гэснийг "үндэсний бодлого хөтөлбөр боловсруулж," гэж өөрчилж, төсөлд тусгав. | **18 дугаар зүйл.Санхүүгийн мэдээллийн албаны чиг үүрэг**<br><br>18.1.8.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан ~~үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг~~ **үндэсний бодлого хөтөлбөр боловсруулж,** Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах; |
| | | 41 | 18.1.8 дахь заалтын "уг стратегийг" гэснийг хасах | | |
| | | 42 | **Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль**:-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн "бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх" гэснийг "үндэсний бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх" гэж засах | "үндэсний хөтөлбөр батлах" гэснийг "үндэсний бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх" гэж өөрчилж, төсөлд тусгав. | **5 дугаар зүйл.Хүн худалдаалахтай тэмцэх талаарх төрийн байгууллагын бүрэн эрх**<br><br>5.1.1.хүн худалдаалахтай тэмцэх үндэсний ~~хөтөлбөр батлах~~ **үндэсний бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх**; |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2020.10.29 01/3823 | 43 | **Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд:** төслийн 1 дүгээр зүйлийн "гэж" гэсний дараа "мөн зүйлийн 6.1.2, 6.2.3 дахь заалтын "үндэсний" гэснийг "бодлого" гэж" гэж тус тус нэмэх | Баяжуулсан хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын "үндэсний хөтөлбөрийг" гэснийг "бодлого хөтөлбөрийг" гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын "үндэсний хөтөлбөр батлах" гэснийг "бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх", 6.2.3 дахь заалтын "үндэсний хөтөлбөрийг" гэснийг "бодлого хөтөлбөрийг" гэж тус тус өөрчилсүгэй. | **6 дугаар зүйл.Хүнс баяжуулалтын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг**<br>6.1.2.баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих ~~үндэсний хөтөлбөрийг~~ **бодлого хөтөлбөрийг** хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлах;<br>6.2.2.баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих ~~үндэсний хөтөлбөр батлах~~ **бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх**;<br>6.2.3.энэ хуулийн 6.2.2-т заасан ~~үндэсний хөтөлбөрийг~~ **бодлого хөтөлбөрийг** хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, өргөн мэдүүлэх; |
| | | 44 | Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хасах | Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хассан. | |
| | | 45 | **Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн зарим заалт хүчингүй болсон тухай хуулийн төсөл:** Хуулийн төслийн гарчгийг "Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" гэж өөрчлөх | хуулийн төслийн гарчгийг өөрчилсөн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 46 | **Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт** оруулах тухай хуулийн төсөлд: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн "... тус тус" гэсний өмнө "16.1 дэх хэсгийн "төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" гэснийг "малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь" гэж, мөн хэсгийн "үндэсний хөтөлбөрийг Засгийн газар батална" гэснийг "асуудлыг хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ" гэж нэмэх | "16.1.Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 7.2-т заасан тайланг үндэслэн малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, ашиглах, хөгжүүлэх асуудлыг хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ." гэж өөрчилж, төсөлд тусгав. | **16 дугаар зүйл. Малын генетик нөөцийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага**<br>~~16.1.Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, энэ хуулийн 7.2-т заасан тайланг үндэслэн малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, ашиглах, хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг Засгийн газар батална.~~**Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 7.2-т заасан тайланг үндэслэн малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, ашиглах, хөгжүүлэх асуудлыг хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.** |
| | | 47 | Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хасах | Хуулийн төслийн 2 дугаар зүйлд тусгасан байсан хүчингүй болсон тооцох тухай заалтыг хуулийг төслөөс хассан. | |
| 13 | Эрүүл мэндийн яам 2020.10.23 1а/4513 | 48 | Доор дурьдсан хуулиудад "Үндэсний хөтөлбөр" гэсэн байгаа тул өөрчлөлт оруулах | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | |
| | | 49 | Авилгын эсрэг хуулийн $2^{1}$1, 6.1.14 | УИХ-ын бүрэн эрхэд хамаарах тул хөндөөгүй. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 50 | | 19.1 УИХ-аас баталж хэрэгжүүлэх боломжтой тул хөндөөгүй. | **19 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах нийтлэг арга хэлбэр**<br>1.Монгол Улс санхүүгийн баталгаа бүхий "Байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-тэй байна. |
| | | 51 | Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 19.1,3.2.14, 13.2, 14.1 | 3.2.14 хуульд харшлаагүй. (Хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй.) | **3 дугаар зүйл. Хуулиар хамгаалах объект, түүнтэй холбогдсон нэр томъёо**<br>14/"байгаль орчны аудит" гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг. |
| | | 52 | | 13.2 дахь заалт нь УИХ-ын бүрэн эрхэд хамаарах тул хөндөхгүй. | **13 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**<br>2/Засгийн газрын өргөн мэдүүлснээр байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах; |
| | | 53 | | 14.1 Засгийн газрын бүрэн эрхийн дагуу хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ажил тул өөрчлөөгүй. | **14 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх**<br>1/байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 54 | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг | Хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **8 дугаар зүйл.Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрх**<br>8.3.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, улсын төсвийн биелэлтийг хангах ажлыг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулна. |
| | | 55 | Монгол хэлний тухай хуулийн 25.1.11 | Тус хуульд ийм заалт байхгүй. | |
| | | 56 | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.2 | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | 7.3.2.Энэ хууль, Эрүүл мэндийн тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Тамхины хяналтын тухай хууль, төрөөс сэтгэцийн эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон холбогдох Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; |
| | | 57 | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 26.4 | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **26 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**<br>4/ тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийг хөгжүүлэх, экологийн аюулгүй байдал, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 58 | Харилцаа холбооны тухай хуулийн 21.1.2 | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | 21.2.Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 21.1-д заасан сүлжээг ашиг олох зорилгоор бусдад ашиглуулахыг хориглох бөгөөд Зохицуулах хороо дотоодын хэрэглээний холбооны сүлжээнд зохицуулалт хийх журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавина. |
| | | 59 | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6.1.3, 7.2.26 | УИХ-ын чуулганаар хэлэлцэгдэж байгаа тул тусгаагүй. | |
| 14 | Эрчим хүчний яам 2020.10.23 а/3418 | 60 | **Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль:** 4.1. УИХ эрчим хүч хэмнэлтийн талаарх хөгжлийн бодлого тодорхойлно | УИХ-ын бүрэн эрхэд хамаарах тул хөндөөгүй. | **4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**<br>4.1.Улсын Их Хурал эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг тодорхойлно. |
| | | 61 | 5.1.1. эрчим хүч хэмнэлтийн талаарх хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангах | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **5 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**<br>5.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангах; |
| | | 62 | 6.1.1. эрчим хүч хэмнэлтийн талаарх хөгжлийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**<br>6.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; |
| | | 63 | 6.1.3. эрчим хүч хэмнэлтийн талаарх хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**<br>6.1.3.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 64 | 7.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангана | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх**<br>7.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангана. |
| | | 65 | 9.1.1. эрчим хүч хэмнэлтийн талаарх хөгжлийн бодлогыг боловсруулах ажлыг зохион байгуулах | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **9 дүгээр зүйл. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрх**<br>9.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; |
| | | 66 | 9.1.2. эрчим хүч хэмнэлтийн талаарх хөгжлийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах | хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй. | **9 дүгээр зүйл. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрх**<br>9.1.2.эрчим хүч хэмнэлтийн талаар үндэсний хөтөлбөр боловсруулах ажлыг зохион байгуулах; |

| | **Нийт саналын тоо** | |
|---|---|---|
| 1 | **Тусгасан саналын тоо** | **26** |
| 2 | **Тусгаагүй саналын тоо** | **40** |
| | Үүнд: | |
| 2.а | Хуулийн төсөлд тусгагдсан байсан | 8 |
| 2.б | УИХ-ын бүрэн эрхэд хамаарах тул хөндөөгүй | 6 |
| 2.в | Хуульд нийцэж байх тул өөрчлөөгүй | 20 |
| 2.г | УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцэгдэж байгаа тул тусгаагүй. | 1 |
| 2.д | Бусад (тус хуульд ийм заалт байхгүй, тусгах санал) | 5 |

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТЫН 2021 ОНЫ 3 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДРИЙН УИХ-03/1989 ТООТ БИЧГЭЭР ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ**

2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр

| Д/д | Ирүүлсэн санал | Саналыг тусгасан эсэх тайлбар | Хуулийн заалтад шигтгэж тусгасан тайлбар |
|---|---|---|---|
| 1 | **Төсөлд нэмж тусгах санал:**<br><br>"6.12.Засгийн газар энэ хуулийн 6.8.2, 16.3-т заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлахдаа тухайн цаг үед тулгамдаж байгаа зайлшгүй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай эрсдлийн үеийн төсөл, арга хэмжээг Улсын Их Хуралд танилцуулснаар төлөвлөгөөндөө тусгаж болно."; | Тусгасан | **6.12.Засгийн газар энэ хуулийн 6.8.2, 16.3-т заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлахдаа тухайн цаг үед тулгамдаж байгаа зайлшгүй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай эрсдлийн үеийн төсөл, арга хэмжээг Улсын Их Хуралд танилцуулснаар төлөвлөгөөндөө тусгаж болно.** |
| 2 | **Төсөлд нэмж тусгах санал:**<br><br>"6.13.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой төрийн дотоод бодлогын баримт бичиг болон гамшиг, онц, дайны байдлын үеийн төлөвлөгөө нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл биш бөгөөд энэ хуулиар зохицуулахгүй." | Тусгасан | **6.13.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой төрийн бодлогын баримт бичиг болон гамшиг, онц, дайны байдлын үеийн төлөвлөгөө нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл биш бөгөөд энэ хуулиар зохицуулахгүй.** |
| 3 | **Төсөлд нэмж тусгах санал:**<br><br>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "**орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгжээс**" гэснийг "**орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан** ажилтнаас" гэж, 9 дүгээр зүйлийн 9.4.7 дахь хэсгийн "төрийн бүх шатны" гэснийг "оролцох төрийн байгууллага" гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн "45 хоногт" гэснийг "90 хоногт" гэж, 18 дугаар зүйлийн | Тусгасан | **7 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо**<br><br>7.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо нь улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, салбарын түвшинд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд, ~~орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгжээс~~ **орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан ажилтнаас** бүрдэнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| | 18.6 дахь хэсгийн “12 дугаар сарын 10-ны” гэснийг “10 дугаар сарын 01-ны” гэж өөрчлөх саналыг Төсөлд нэмж тусгах. | | 9.4.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг:<br><br>9.4.7.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад ~~төрийн бүх шатны~~ **оролцох төрийн байгууллага** болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг хангаж, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэний оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх;<br><br>**17 дугаар зүйл. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн цаглавар**<br><br>17.4. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Засаг даргыг томилогдсоны дараах 4~~5 хоног~~ **90 хоногт** багтаан батална. |
| 4 | **Төслөөс хасах санал:**<br><br>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хасах буюу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалтыг хэвээр үлдээх. | **Тусгах боломжгүй**<br><br>Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн хувилбараар хуулийн төсөлд тусгасан. | 9.4.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг:<br><br>~~9.4.3.макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх;~~<br><br>**“9.4.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар санал дүгнэлт боловсруулж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;”** |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | **Төсөлтэй холбогдох найруулгын санал:**<br><br>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан "6.11.Бусад хууль тогтоомжид заасан төрөөс баримтлах бодлого нь энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөлд, үндэсний хөтөлбөр нь мөн зүйлийн 6.5-д заасан хөгжлийн зорилтот хөтөлбөрт тус тус хамаарна." гэснийг "6.11.Бусад хууль тогтоомжид заасан төрөөс баримтлах бодлого гэснийг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөлд хамааруулж, үндэсний хөтөлбөр гэснийг мөн зүйлийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тус тус хамааруулж ойлгоно." гэж өөрчлөх | Тусгасан | **6.11.Бусад хууль тогтоомжид заасан төрөөс баримтлах бодлого гэснийг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.5, 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөлд хамааруулж, үндэсний хөтөлбөр гэснийг мөн зүйлийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тус тус хамааруулж ойлгоно.** |

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| № | Нэр | Албан тушаал | Холбоо барих, утас |
|---|---|---|---|
| 1 | Ц.Нямдорж | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга | |
| 2 | Б.Жавхлан | Сангийн Сайд | |
| 3 | Б.Энх-Амгалан | Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга | 99116676 |
| 4 | С.Наранцогт | Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга | 99003447 |
| 5 | Н.Мягмар | Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга | 99109376 |
| 6 | П.Зохихсүрэн | Засгийн газрын хэрэг эрхлэх газар Бодлого, төлөвлөлтийн газрын дарга | 99000730 |
| 7 | Х.Батжаргал | Үндэсний хөгжлийн газрын дарга | 99114268 |
| 8 | Г.Батхүрэл | Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга | 99116659 |
| 9 | П.Сайнзориг | Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга | 88110079 |